

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2022.03.10	A/72	Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн мөнгийг буцаан олгох тухай	
2	Аймгийн Засаг дарга	2022.03.22	A/90	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2022.03.22	Б/15	Дэмжлэг үзүүлэх тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 70384096, 88089938

И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/72

Мөрөн сум

Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн
мөнгийг буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн санд 2021 оны жилийн эцэст нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 57,846,118 (тавин долоон сая найман зуун дөчин зургаан мянга нэг зуун арван найм) төгрөг, Соёл урлагийн газрын 15,000,000 (арван таван сая) төгрөгийг тухайн байгууллагуудад буцаан олгосугай.

2. Хөгжимт драмын театрын 2,130 (хоёр мянга нэг зуун гуч) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын 31,241 (гучин нэгэн мянга хоёр зуун дөчин нэг) төгрөг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5,500 (таван мянга таван зуу) төгрөгийг тус тус аймгийн орлогод тооцугай.

3. Байгууллагуудын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 72,846,118 (далан хоёр сая найман зуун дөчин зургаан мянга нэг зуун арван найм) төгрөгийг буцаан олгож, 38,871 (гучин найман мянга найман зуун далан нэг) төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Гантулга) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 5/15

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7.3,15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дугаар хурлын шийдвэрийг тус-тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд зохион байгуулагдаж байгаа RAW CLGSSIC Пауэрлифтингийн хойд бүсийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээний үйл ажиллагааны зардалд 5,500,000 (Таван сая таван зуун мянга) төгрөг, иргэн Л.Батцэцэгийн “Амьдрал хөглөсөн аялгуу” уран бүтээлийн тоглолтод 1,000,000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 6,500,000 (Зургаан сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлог гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/90

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл салбарын үйл ажиллагааны дэмжлэгт 5,000,000 төгрөгийг олгосугай.

2. Дээрх зардлын 5,000,000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын ерөнхий данснаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал) -д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулж, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг ханган, тайлагнахыг Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл салбарын дарга (Ж.Сарангэрэл)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат) -т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

